



БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ ХК

2020 оны хагас жилийн тайлан

# АГУУЛГА

## Бизнесийн үйл ажиллагаа

- ❖ Компаний тухай товчхон
- ❖ Эрхэм зорилго
- ❖ Алсын хараа
- ❖ Чанарын бодлого
- ❖ Онцлох үйл явдлын хураангуй
- ❖ Компаний засаглал
- ❖ ТУЗ, гүйцэтгэх удирдлага
- ❖ Үнэт цаасны мэдээлэл

## Санхүүгийн үйл ажиллагаа

- ❖ Санхүүгийн тайлан түүний шинжилгээ
- ❖ Борлуулалтын орлого бүтцээр
- ❖ Хөрөнгө оруулалт



### *Товч танилцуулга:*

Хагас зуун жил Монголын Аялал жуулчлал, зочлох үйлчилгээ, зочид буудал, үйлчилгээний салбарын хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэсээр ирсэн “Баянгол зочид буудал” ХК нь 1964 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 375 тоот тогтоол гарч, Ажилчны хорооны нутаг дэвсгэр, 220 мянгатын 80 айлын орон сууцны барилгад 200 ортой зочид буудал байгуулахыг хотын АДХГЗ-д даалгаснаар манай анхны үйлчилгээ эхэлсэн түүхтэй.

“Баянгол зочид буудал” нь Засгийн Газрын өмч хувьчлалын Комиссын 1991 оны 12 сарын 11 өдрийн 27-р тогтоолоор “Баянгол зочид буудал” ХК, хувийн хэвшлийн аж ахуй болон өөрчлөгдөж анхны хувь нийлүүлсэн зочид буудал болсон байна. Өнөөдөр нэг мянга гаруй хувь нийлүүлэгчтэй, жил бүр тогтмол ноогдол ашиг хуваарилдаг, үйл ажиллагаа нь тогтмолжсон, хөрөнгийн биржийн ТОП-20 индекст багтдаг томоохон компаниудын нэг болно.

### *Эрхэм зорилго:*

“Баянгол зочид буудал хувьцаат компани нь зочдоо дээдэлсэн, зочин бүртээ чин сэтгэлээсээ үйлчилдэг байгууллага”

### *Алсын хараа:*

“Баянгол Зочид Буудал” ХК-нь зочлохуйн үйлчилгээний салбарт тэргүүлэх чиглэл баримтлан, гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллаж, олон улсын үйлчилгээний стандарт, дэвшилтэт шинэ үйлчилгээ, техник төхөөрөмж ашиглан, чадварлаг баг, ажилтантайгаар “Баянгол бренд”-ийн үйлчилгээг бий болгоно.

### *Чанарын бодлого:*

Зочид, үйлчлүүлэгчиддээ тав тухтай, эрүүл, аюулгүй орчинд дэвшилтэт техник технологи, уламжлалт хэв шинжийг хадгалсан чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг чадварлаг, туршлагатай ажилтнууд хүргэнэ.

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

Баянгол зочид буудал нь УОК-с улс даяар мөрдүүлж буй хууль, журам, дэглэмийн хүрээнд дараах ажлуудыг хийсэн:

COVID-19 вирусн халдвараас урьдчилан сэргийлэх анхааруулга явагдаж эхэлсэн цагаас эхлэн нийт үйлчлүүлэгчид, ажилчиддаа халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж зааврыг тогтмол өгч, гар ариутгал хийх болон маскжуулах

Зочдын халууныг хэмжиж бүртгэх, Дотоодын ариутгал цэвэрлэгээг тогтмол хийх зэрэг эрүүл мэндийн байгууллагаас өгсөн заавар зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллуудыг хийн ажилсаар байна

ХӨСҮТ-ийн удирдамжийн дагуу халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор ажилчдадаа шат дараалсан шинжилгээг хийлгэж, шинжилгээний хариу сөрөг гарсан.

Зоонозын өвчин судлалын үндэсний төв, “Ариун Орчин” ХХК-аар үйлчилгээний бүх цэгүүдийг хамруулан нийт 4000 мкв талбайд Ариутгал, халдваргүйжүүлэлтыг тогтмол хийлгэж байна

"Дархлаа дэмжих сан" байгуулан ажилчид, албан хаагчиддаа мөнгөн болон материаллаг дэмжлэг үзүүлсэн.

Ажлын байрыг хадгалан ажлын цагийг богиносгож, ажилчидаа “Дэмжлэг”-т бүрэн хамруулсан

Хамтран ажиллагч байгууллагуудын түрээсийн төлбөрт хөнгөлөлт үзүүлсэн.

Дэлхийн олон оронд тархаад байгаа короно  
вируст халдвар (covid-19)-аас иргэдээ  
хамгаалах,урьдчилан сэргийлэх, бэлэн  
байдлыг хангах үйлсэд ажилчдын нэг  
өдрийн цалингаа хандивласан






COVID -19 цар тахалтай холбоотойгоор ДЭМБ, УОК, ЭМЯ, НОК, ХӨСҮТ, ЗӨСҮТ, ЦЕГ, МХГ, НЗДаргын захирамж, зөвлөмжийг удирдлага болгон хэрэгжүүлэн ажилласаар байна

# Халдвар хамгаалал онцгой байдлын үедч бид үйлчилгээгээ зочиддоо хүргэсээр байна



Үйлчлүүлэгчдийнхээ дархлаа дэмжих зорилгоор “Хадаан” тасалсан гурилтай аарцтай шөл, “Хамаг монгол” хавиргатай шөл зэрэг шим тэжээлтэй хоол хүнсээр үйлчилсэн.

Гэгээн хайрын Валентины баярын багцуудыг заралсан.



Баянгол ресторан хэрэглэгч үйлчлүүлэгчдийнхээ хүсэлтээр нэрийн тоортоо гаргаж эхэлсэн



2020 оны 3 сарыг дуустал зочиддоо  
Буфет өглөөний цай, Буудлын үйлчилгээ,  
Wine рестораны үйлчилгээндээ  
хямдралуудыг зарласан.

Үйлчлүүлэгчдийнхээ оройг тав тухтай,  
тухлаг орчинд амтлаг дарс шимэн найз  
нөхдийн хамт цагийг зугаатай  
өнгөрүүлээрэх боломжийг бүрдүүлэн  
"Wine House" рестораны "Share food"-ээр  
үйлчилсэн



Bayangol Hotel  
"Монголын Нэг Өдөр"  
Ресторан

МНГМАР, ПУРЭВ ГАРИГУУДАД

ӨДГ 1  
ЦЭЦЭЭН  
МОНГОЛЫН ХАМ ТУУЛ  
БУУГААНЫ  
БУЛГАГАА МАСЛО

ӨДГ 2  
ЦЭЦЭЭН  
МОНГОЛЫН ХАМ ТУУЛ  
БУУГААНЫ  
БУЛГАГАА МАСЛО

ДАВАА, ЛХАГВА, БААСАН ГАРИГУУДАД

ӨДГ 3  
ЦЭЦЭЭН  
МОНГОЛЫН ХАМ ТУУЛ  
БУУГААНЫ  
БУЛГАГАА МАСЛО

ӨДГ 4  
ЦЭЦЭЭН  
МОНГОЛЫН ХАМ ТУУЛ  
БУУГААНЫ  
БУЛГАГАА МАСЛО

*Business lunch set*  
**9999 ₮**

АЖЛЫН  
ӨДРҮҮДЭД  
12:00-15:00

11-312255  
94095855

"Монголын Нэг Өдөр" Ресторан  
Баянгол зочид буудал "Б"  
корпус 2-р давхарт

“Монголын Нэг Өдөр” рестораныг шинэчлэн засвар шинэчлэлт хийж, зочид үйлчлүүлэгчдийнхээ дархлааг дэмжих зорилгоор ланч сет санал болгож байгаа нь үйлчлүүлэгчдийн таашаалд нийцээд байна.



Баянгол ресторан нь өргөн сонголт бүхий гэр бүлийн багцуудаар үйлчилж эхэлсэн



Баянгол ресторанд бүрэн засвар хийгдэж, зочид үйлчлүүлэгчдийнхээ тав тухтай орчныг  
бүрдүүлсэн



Ажилчдын нийгмийн асуудлыг дэмжих жилийн хүрээнд “ОРОН СУУЦНЫ УРЬДЧИЛГААНД ЗОРИУЛСАН УРТ ХУГАЦААТАЙ, ХҮҮГҮЙ ЗЭЭЛ” компаниас авах эрхийг Ажлын үр дүн, бүтээлч хөдөлмөр, урт хугацаанд үр бүтээлтэй ажилласан хөдөлмөрч ажилтандаа гардуулан өгсөн.

Цар тахлын улмаас үйлчилгээний хязгаарлалт тогтоосон байгаа боловч ажилчиддаа үйлчилгээний болон хөдөлмөр хамгаалалын сургалтуудыг тогтмол явуулж байна

“Баянгол зочид буудал” ХК-ийн хувьд компанийн засаглалын кодексийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа байдал

Хувьцаа эзэмшигчид

- Компаний хөрөнгө оруулагчид
- ТУЗ-ийн гишүүдийг сонгох, чөлөөлөх
- Хуулийн дагуу эрхээ бүрэн эдлэх

ТУЗ

- Хувьцаа эзэмшигчийг төлөөлнө
- Компаний стратеги
- Гүйцэтгэх удирдлагыг удирдамжаар хангах
- Гүйцэтгэх удирдлагад хяналт тавих

Гүйцэтгэх удирдлага

- Стратегийг хэрэгжүүлнэ
- Өдөр тутмын үйл ажиллагааг зөв зохистой зохион байгуулна
- ТУЗ болон ХЭ-ийн өмнө ажлаа тайлагнана

## ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

ТУЗ-ийн бүтэц, гишүүдийн ур чадвар, ажлын туршлага, тэдгээрийн компанид үзүүлж буй хувь нэмэр

### ТУЗ-ийн дарга

Нэр	Базарын Аюуш
Боловсрол	МУИС, Оросын ЭЗ-ийн академи
Мэргэжил	Худалдааны нягтлан бодогч, Эдийн засагч
Ажлын туршлага	1975-1977 ТТХЕГазар орлогч ня-бо 1977-1994 МУИС-д багш 1994-2012 СЗХороонд хэлтсийн дарга, газрын орлогч дарга, даргын зөвлөх 2012 оноос Сангийн яамны зөвлөх
Цол зэрэг:	Эдийн засгийн ухааны доктор /Ph.D/ Алтан гадас одон, Санхүү банкны тэргүүний ажилтан, Бүртгэл статистикийн тэргүүний ажилтан, Хөрөнгийн зах зээлийн хүндэт тэмдэг
Компанид үзүүлж буй хувь нэмэр	--Аудитын хорооны дарга, --Шагнал урамшуулал, цалин хөлсний хорооны дарга

## ТУЗ-ийн гицүүд

Нэр	Х.Цэндбаяр	Х.Баттуул	Билли Лим	М.Золжаргал	З.Цэрэнчимэг
Боловсрол	Багшийн дээд сургууль, Удирдлагын академи	Багшийн дээд сургууль	Политехникийн дээд сургууль	БНСУ, Хандонг их сургууль	Боловсрол
Мэргэжил	Багш, Бизнесийн удирдлага	Биеийн тамирын багш	Инженер	Аялал жуулчлалын зохицуулалтын менежмент	Нябо, эдийн засагч, Бизнес удирдлагын арга зүйч
Ажлын туршлага	--1985-1997 34р дунд сургууль багш --1997-1998 Женко компани менежер --1998-2001 Countryside restaurant Гүйцэтгэх захирал --2000 оноос БГЗБ ХК гүйцэтгэх захирал	--1983-1990 улсын шигшээ багт тамирчин --1993-2019 Женко дэд захирал --1995-1998 Brother ХХК захирал --1998-2002 GAG гүйцэтгэх захирал --2002 оноос “Талх- чихэр” ХХК гүйцэтгэх захирал --2008-2011 Чингис Маркет ХХК Ерөнхий захирал	--1982-1991 София ХХК Гүйцэтгэх захирал --1991-2004, --2006 оноос МСВ ХХК Гүйцэтгэх захирал --2004-2006 БГЗБ ХК Гүйцэтгэх захирал	--2005-2006 БГЗБ ХК ерөнхий менежер туслах --2008-2009 GTV ХК Маркетингийн албаны дарга --2009-2012 БНСУ-ын Корес төлөөлөгчийн газар, менежер --2012 оноос Verve Wine ХХК Захирал	--1984-1992 ГЖҮГ-ын авто баазад ахлах нябо --1992-2008 БГЗБ ерөнхий нябо --2008-2016 ЗТХБЯ, ЗТЯ, Сайдын багцын Ерөнхий нябо бөгөөд санхүү хэлтсийн дарга --2016 оноос БГЗБ ерөнхий менежер
Цол зэрэг:	Хөдөлмөрийн хүндэт медаль, Алтан гадас одон	Чөлөөт бөхийн олон улсын хэмжээний мастер		Менежментийн магистр	МУ-ын мэргэшсэн нягтлан бодогч, Гавьяат эдийн засагч
Компанид үзүүлж буй хувь нэмэр	--Аудитын хорооны гишүүн --Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	--Шагнал урамшуулал, цалин хөлсний хорооны гишүүн			--Аудитын хорооны гишүүн

## ТУЗ-ийн хараат бус гишүүд

Нэр	Д.Батжаргал	Ц.Хэнмэдэх	Д.Цэнддорж
Боловсрол	Ростовын УИС, Маастрихтийн менежментийн сургууль	--Москвагийн УАААД	--1972-1976 он МУИС,
Мэргэжил	Эдийн засагч	Худалдааны бараа судлаач	Инженер, улс төр судлаач
Ажлын туршлага	1987-1991 ОХБДС багш, 1991-2004 оноос СЭЗДС-ийн орлогч захирал, захирал 1999-2000 УТЕГ-ын дарга	--1962-1972 ХБЯ-ны бөөний худалдааны газар мэргэжилтэн, орлогч дарга --1972-1980 ГХЯ-ны импорт нэгдэлд орлогч дарга --1980-1986 ЗХУ-д Худалдааны төлөөлөгчийн газар орлогч дарга --1986-2007 онд БГЗБ ХК-ийн дарга, захирал, дэд захирал --2007 оноос компанийн зөвлөх	--1977-1982 УХТЭШ инженер, зургийн экспедицийн дарга --1982-1991 МХЗЭ-ийн Төв хороонд ахлах реферант --1991-1997 УБ хотын МАХН-ын хороонд ахлах реферант МУ-ын ерөнхий сайдын дэргэдэх Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн ажлын албанд ахлах ажилтан, төслийн удирдагч --1997-2006 Женко ХХК-д зөвлөх
Цол зэрэг:	Бизнесийн удирдлагын магистр, Эдийн засгийн ухааны доктор, Монгол улсын гавьяат багш	Үйлчилгээний гавьяат ажилтан	Инженер, техникийн ухааны магистр, улс төр судлаач
Компанид үзүүлж буй хувь нэмэр	Нэр дэвшүүлэх хорооны дарга	Шагнал урамшуулал, цалин хөлсний хорооны дарга	--Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

### ТУЗ-ийн гишүүдийн хувьцаа эзэмшилт

Нэр	Гишүүнчлэл	Хувьцааны хувь
Билли Лим	ТУЗ-ийн гишүүн	16.32%
Х.Баттуул	ТУЗ-ийн гишүүн	16.30%
Х.Цэндбаяр	ТУЗ-ийн гишүүн	14.79%
З.Цэрэнчимэг	ТУЗ-ийн гишүүн	3.29%
М.Золжаргал	ТУЗ-ийн гишүүн	0%
Д.Батжаргал	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0%
Б.Аюуш	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0%
Д.Цэнддорж	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0%
Ц.Хэнмэдэх	ТУЗ-ийн хараат бус гишүүн	0%



## ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ


“Баянгол Зочид Буудал” ХК нь 1964 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 375 тоот тогтоолын дагуу анхны үйлчилгээг эхлүүлэ байсан түүхтэй. 1991.12.11-ний өдрийн Засгийн газрын өмч хувьчлалын комиссын 27-р тогтоолоор “Баянгол Зочид Буудал ХК” хувийн хэвшлийн аж ахуй болон өөрчлөгдөж анхны хувь нийлүүлсэн зочид буудал болсон байна.

“Баянгол Зочид Буудал” ХК нь 1991 онд ХК болсноосоо хойш хувьцаа эзэмшигч нарт жил бүр тогтмол ноогдол ашиг хувиарлаж байгаа бөгөөд энэ хугацаанд нийт 2 тэрбум төгрөгийн ноогдол ашиг хувиарласан байна.


№	Овог Нэр	Эзэмшиж буй хувьцааны хувь
1	Х Баттулга	20.00%
2	Х Баттуул	16.30%
3	Билли Лим Син Пау	16.32%
4	Х Цэндбаяр	14.79%

## Дэлхий нийтийг хамарсан цар тахалаас үүдэн аялал жуучлал зочид буудлын үйл ажиллагаа бүрэн зогссон

### Хагас жилийн орлогын тайлангийн шинжилгээ (мян.₮)




### Борлуулалтын орлогын бүтэц



2019 оныг хагас жилийг суурь он болгож үзэхэд 2020 оны хагас жилээр борлуулалтын орлого суурь оноосоо 4,6 дахин буурсан . Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 2,3 дахин буурсан нь орлоготой холбоотой бөгөөд үйл ажиллагаатай холбоогүйгээр цалин, элэгдэл, тогтмол зардлууд гарсаар байгаа нь өртөгт нөлөөлж байна.

## Хагас жилийн орлогын бүтэц сар сараар



## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2020 оны хагас жилийн байдлаар 302,4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажлууд хийгдсэн байна.

д/д	Хөрөнгө оруулалт, их засвар:	Үнийн дүн /сая ₮/
1	Баянгол рестораны засвар, тохижилт	91,4
2	Б буудлын 10,11,12 давхрын засвар, тохижилт	149,0
3	Монголын нэг өдөр рестораны засвар, тохижилт	41,0
4	Оффисийн засвар, тохижилт	21,0
5	Гадаа тайлбайн цэцэрлэгжүүлэлт	2,0
	Нийт хөрөнгө оруулалтын дүн	304,4

Анхаарал тавьсанд баярлалаа